



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/50.

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдээс Хөвсгөл аймгийн “Могойн гол”ХК-ний нүүрсний уурхайгаас хүнд даацын тээврийн хэрэгслүүд Мөрөн, Эрдэнэтийн чиглэлд ямар ч зохицуулалтгүй зорчиж, замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдахааргүй нөхцөл байдал үүсэж, авто зам, замын байгууламжид эвдрэл, гэмтэл учруулж болзошгүй байгаа талаар гомдол мэдээлэл их ирж байгаатай холбогдуулан тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, хэрхэн шийдвэрлэх талаар оновчтой шийдэл гаргах, хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Алтаншагай

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд:

Н.Төмөрхуяг

(Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын  
албаны орон нутгийн өмчит компани, шагнал  
хариуцсан ажилтан /тохиролцсоноор/)

Х.Даваасүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн мэргэжилтэн)

Ө.Баттулга  
Б.Батбаатар

(Хөвсгөл аймгийн Автотээврийн төвийн дарга)  
(аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн  
тасгийн дарга)

Д.Даваасүрэн

(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)  
(Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит үйлдвэрийн  
газрын захирал)

Б.Галбадрах

Н.Буян-өлзий

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн мэргэжилтэн авто замын хяналтын  
улсын байцаагч)

Ж.Нямхүү

(“Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит  
үйлдвэрийн газрын харьяа Хөвсгөл Мөрөн Төлбөр  
авах цэг)

Захирамж-2023

671 0102 19



2.

Нарийн бичгийн дарга:  
Ё.Ариунзаяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн автотээврийн хяналтын улсын байцаагч)

2. Хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Мөнгөн-эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН